

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар НТ-24/025

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
А/1538 дугаар захирамжийг үндэслэн

Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Улаанбаатар хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ" ОНӨААТҮГ
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг	Улаанбаатар, Хан-Уул, 10-р хороо, Өөрийн байранд
Регистрийн дугаар	7037793
Тусгай нөхцөл, шаардлага	Холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ биелүүлж ажиллах.
Тусгай зөвшөөрлийг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 5 (тав) жилийн хугацаатай олгов.	



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Улаанбаатар хот





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/1538

Улаанбаатар хот

“Нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.12 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэрийн дагуу Улаанбаатар хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг энэхүү захирамжийн хавсралтад заасан 5 хуулийн этгээдэд таван жилийн хугацаатай олгосугай.

2.Нийслэлийн нутаг дэвсгэрт хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-д төвлөрүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хавсралтад заасан хуулийн этгээдэд, хураамж төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Татварын газар (М.Болдбаатар)-т, Сангийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Энхжин)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, зөвшөөрөл олгосон өдрөөс 6 сарын дотор зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьж үр дүнг танилцуулж, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг шийдвэрлүүлэн ажиллахыг Нийтийн тээврийн бодлогын газар (Д.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Т.Даваадалай)-д даалгасугай

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110207008

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...12... дугаар сарын 30-ны өдрийн
...1538 дугаар... захирамжийн
хавсралт

УЛААНБААТАР ХОТ ДОТОРХ БОЛОН ХОТ ОРЧМЫН НИЙТИЙН ЗОРЧИГЧ
ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Д/д	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Үйлчилгээний төрөл
1	"Сайхан-Ирээдүй" ХХК	2705443	5 /тав/ жил	Үндсэн
2	"Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ	7037793	5 /тав/ жил	Үндсэн
3	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	8286019	5 /тав/ жил	Үндсэн
4	"Үнэгтийн Уул" ХХК	5129508	5 /тав/ жил	Үндсэн

ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Д/д	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Үйлчилгээний төрөл
1.	"Тэбэ сервис" ХХК	2727668	5 /тав/ жил	Такси